

“ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТҮНШЛЭЛИЙН КОМПАКТ: ХҮН ХУДАЛДААЛАХААС ХҮҮХДИЙГ ХАМГААЛАХ НЬ” ТӨСӨЛ

“Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг гэмт хэргийн хохирлыг
нөхөн төлүүлж байх практик бодлогын судалгаа”

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ АЖЛЫН ДААЛГАВАР

Монгол Улсын Засгийн газар, Америкийн Нэгдсэн Улсын Төрийн Департамент хооронд байгуулсан “Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт” Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь төсөл дөрөв дэх жилдээ хэрэгжиж байна.

Төсөл нь Монгол Улсад хүүхэд худалдаалсан гэмт этгээдийг хуулийн дагуу яллаж, зохих ял шийтгэлийг оногдуулах чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагын чадавхыг бэхжүүлж, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдэд учирсан гэмтэл, хохирлыг нөхөн сэргээхэд чиглэсэн цогц үйлчилгээ үзүүлж, улмаар Монгол Улс даяар хүүхэд худалдаалах гэмт хэргийн бүх төрлөөс урьдчилсан сэргийлэх зорилготой.

Энэхүү төслийг Монгол Улсын Засгийн газрыг төлөөлөн Хууль зүй, дотоод хэргийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Улсын ерөнхий прокурорын газар, Гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба ерөнхий удирдлагаар хангаж, “Дэлхийн зөн Монгол” олон улсын байгууллага, “Азийн сан” олон улсын байгууллага хамтран хэрэгжүүлж байна.

Зөвлөх үйлчилгээний зорилго:

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүн худалдаалах гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, орлогыг олж тогтоох, битүүмжлэх, хураах, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулах, нөхөн олговрын механизмын талаар олон улсын туршлагыг судалж, өөрийн орны хууль эрх зүйн орчинтой харьцуулан хохирогчид нөхөн төлбөр олгуулах үр ашигтай эрх зүйн орчин, механизмын талаар харьцуулсан дүгнэлт гаргаж, хэрэгжүүлэх санал, зөвлөмж боловсруулах

Ажлын даалгавар:

Судлаач гурваас доошгүй улсыг сонгож өөрийн орны хууль эрхзүйн орчин, механизмтай харьцуулан судалгаа хийнэ.

1. Хүн худалдаалах гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, орлогыг олж тогтоож буй хууль зүйн үндэслэл, зохицуулалт
2. Сайн дураар болон албадлагын журмаар нөхөн олговор олгох зохицуулалт, механизм, хэрэгжилт
3. Гэмт хэргийн улмаас олсон хөрөнгийг олж тогтоон битүүмжилсний дараа нөхөн олговор олгох шийдвэрийг биелүүлэх, хохирол барагдуулах талаарх зохицуулалт, хэрэгжилт
4. Гэм буруутай этгээдийн хөрөнгийг хурааж хохирлыг барагдуулах, хохирогчид дэмжлэг үзүүлэх, нөхөн сэргээхэд зарцуулах, эсвэл сан байгуулж ажиллах гм хэрхэн зарцуулж буй туршлага, өөрийн оронд хэрэгжүүлэх боломжийн талаар
5. Нөхөн төлбөр авахад хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид тулгардаг практик хүндрэлүүд, түүнийг даван гарч буй бусад улсын сайн туршлага

6. Хохирогчид нөхөн төлбөр олгуулах үр ашигтай механизмын олон улсын зохицуулалт, манай улсад хэрэгжүүлэх боломж
7. Судалгааны үр дүнгийн тайланг төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагын дунд нэгдсэн хэлэлцүүлэг зохион байгуулах, тэднээс гарсан саналыг тусгах;
8. Захиалагч байгууллага болон хэлэлцүүлгээс гаргасан санал, зөвлөмжийг тусган эцсийн тайланг оролцогч талуудад хүлээлгэн өгснөөр дуусгавар болно.

Зөвлөх үйлчилгээний хугацаа:

Зөвлөх багийн ажил гүйцэтгэх хугацаа нь 2024 оны 03 дугаар сараас 05 дугаар сарыг дуустал үргэлжилнэ.

Эхлэлийн тайлан: 2024 оны 04-р сарын 15
Эцсийн тайлан: 2024 оны 05-р сарын 31

Зөвлөх үйлчилгээ үзүүлэгчид тавигдах шаардлага:

1. Зөвлөх үйлчилгээний үндсэн гүйцэтгэгч нь хуулийн этгээд байх;
2. Мэргэшсэн хүний нөөцтэй байх: эрх зүйч (эрүүгийн эрх зүй, гэмт хэргийн хохирогч хүүхдэд өмгөөллийн үйлчилгээг дагнан үзүүлж байсан туршлагатай бол давуу тал болно), нийгмийн халамж, хамгааллын магистр болон түүнээс дээш зэрэгтэй, мэргэжлээрээ 2-оос доошгүй жил ажилласан туршлагатай хүний нөөцтэй байх;
3. Ур чадвар: Мэдээлэл нэгтгэн боловсруулах, дүн шинжилгээ хийх чадвартай, англи хэлний ярианы болон бичгийн чадвартай байх;

Бүрдүүлэх материал:

1. Байгууллагын танилцуулга (сүүлийн 3 жилийн хугацаанд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа болон судалгааны жагсаалт)
2. Гишүүдийн танилцуулга
3. Үйл ажиллагааны төлөвлөгөө, үнийн саналыг хамт ирүүлнэ.